



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
АЛБА

Иргэдэд үйлчлэх төв байр, Чингисийн өргөн чөлөө,  
20 дугаар хороо, Хан-Уул дүүрэг  
Улаанбаатар хот, 17042, Утас: (976) 7000 9011  
Цахим шуудан: info@hud-procurement.mn  
Цахим хуудас: www.hud-procurement.mn

2024.05.28 № 291  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу гаргах тухай

Тус албанаас зохион байгуулсан Цэцэрлэгийн барилга (20 дугаар хороо), ХУДХААА/20240101104 дугаартай ажилд оролцохоор сонирхогчийн гаргасан тодруулгын хүрээнд хариу хүргүүлэх нь:

1. Магадлалаар баталгаажсан төсвийн дагуу төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж болох эсэх тухайд ТШЗ 21.6-д “Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: Тохируулахгүй, тогтмол байна” гэж заасан бөгөөд сонирхогч аж ахуйн нэгжийн хувьд өөрсдөө газраа санал болгож байгаа тул нарийн хэмжилт хийж тооцоолол хийх боломжтой учраас санал болгосон үнийн саналын дагуу ажил гүйцэтгэнэ.

2. Санал болгож буй газрын эзэмшигчтэй байгуулсан гэрээг хэрхэн хавсаргах тухайд ТШЗ 19.2-ын 5.3-т “Санал болгож буй газрын талаарх холбогдох баримт бичиг болон газрын фото зургийн хамт ирүүлнэ” гэж заасан бөгөөд энэ хэсэгт санал болгож буй газрын холбогдох нотлох бичиг баримтыг тендерт хавсарган ирүүлэх бөгөөд цахим системд түншлэл эсвэл туслан гүйцэтгэгчээр бүртгүүлэх шаардлагагүй болно.

3. Барилга угсралтын ажилд шаардлагатай Ковш машинаар Бульдозерийг орлуулж болох эсэх тухайд үнэлгээний хороо дээрх асуудлаар хуралдан “Бульдозер эсвэл Ковш” санал болгоно гэж оруулахаар болсныг мэдэгдье. Цахим системд байршуулсан тендер шалгаруулалтын баримт бичигт дээрх заалттай холбоотой өөрчлөлт орох тул дахин татан авч ашиглахыг зөвлөө.